



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 10 сарын 12 өдөр


Дугаар 308

Гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Польш Улсын Үндэсний Боловсрол, Спортын яам хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны 2005 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 2/2410 тоот болон Бүгд Найрамдах Польш Улсын Хууль зүйн яамны Хууль, эрх зүйн газрын дэд захирал Анджей Невельскийн 2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн РЗ/3905 тоот албан бичгүүд, Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн Хуулийн Цэцийн гишүүн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Мариан Гжыбовскийн 2005 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн болон Бүгд Найрамдах Польш Улсын Ягеллоны их сургуулийн докторантурын албаны 2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн тодорхойлолтууд, 2005 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Бүгд Найрамдах Польш Улсын Хууль зүйн сайд бөгөөд Улсын Ерөнхий прокурор Анджей Калвастай хийсэн ярилцлагын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Содном овогтой Отгонгэрэлийг 2005-2006 оны хичээлийн жилээс Бүгд Найрамдах Польш Улсын Краков хотын Ягеллоны Их сургуулийн докторантурт хууль зүйн чиглэлээр 4 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Содном овогтой Отгонгэрэлийг Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Польш Улсын Үндэсний Боловсрол, Спортын яам хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу 2006-2007 оны хичээлийн жилийн докторын түвшний сургалтад суралцуулах хуваарьт хамруулан зохих журмын дагуу гэрээ байгуулж, төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



П.ЦАГААН

0000110